

“Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?”

Улсын X олимпиад

Зорилго:

Энэхүү уралдааны зорилго нь Эдийн засгийн онолын хичээлийг судалж буй их, дээд сургуулийн оюутнуудын онолын мэдлэг чадварыг хөгжүүлж, авхаалж самбааг сорих, цаашид экономиксийг судлах сонирхлыг дэмжихэд оршино.

Оролцох оюутнууд:

- ✓ “Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?” улсын уралдаан нь Монгол улсын хэмжээнд эдийн засгийн онолын хичээлийг судалдаг бүх их, дээд сургуулиудын 1-р ангийн оюутнуудад нээлттэй.
- ✓ Оюутнууд нь баг бүрдүүлж оролцох ба баг тус бүр нэг сургуулийн 5 оюутнаас бүрдсэн байна.
- ✓ Баг тус бүр оноосон нэртэй байна.

Хамрах сэдэв:

1-р шатанд:

- ✓ Микроэкономиксийн үндэс хичээлийн бүх сэдэв
- ✓ Макроэкономиксийн үндэс хичээлийн дараах сэдвүүд
 - Үндэсний тооцооны систем
 - Эдийн засгийн өсөлт, бүтээмж
 - Хадгаламж, хөрөнгө оруулалт, санхүүгийн систем
 - Ажилгүйдэл, түүнийг хэмжих
 - Мөнгө, мөнгөний үүрэг, төв банк, мөнгөний нийлүүлэлт
 - Инфляци, түүний шалтгаан, инфляцийн зардлууд
 - Олон улсын худалдааны онол, худалдааны бодлого
 - Бодит болон нэрлэсэн валютын ханш
 - Эдийн засгийн хэлбэлзэл
 - Нийт эрэлт, нийлүүлэлтийн загвар

2-р шатанд:

- ✓ Микроэкономикс болон макроэкономиксийн үндэс хичээлийн бүх сэдвийг хамарна

Олимпиад 2 үе шаттай явагдана.

1-р шат нь 2013 оны 5 сарын 5-нд 11⁰⁰ цагаас

- А хэсэг: МУИС 4-р байр
- В хэсэг: МУИС 5-р байр

Энэ шатанд оюутнуудын эдийн засгийн онолын суурь мэдлэгийг тестээр шалгана. Тестийн үр дүнгээр багуудыг жагсааж сургууль бүрийн хамгийн өндөр оноотой зөвхөн **НЭГ** багийг дараагийн шатанд шалгаруулан долоон багийг II шатанд оролцуулна. “ МУИС-ЭЗС-ийн оролцогч оюутны тоо олон байдаг тул хоёр баг, өөр сургуулиудаас нэг нэг нийт долоон баг дараагийн шатанд оролцоно.

Жич: Нэг сургуулийн хоёр багийн оноо тэнцвэл багийн ахлагчийн оноогоор шийдвэрлэнэ. Хэрэв багийн ахлагчийн оноо тэнцвэл багийн гишүүдийн онооны аль хэлбэлзэл багатай багийг дараагийн шатанд оруулна.

2-р шат нь 2013 оны 5 сарын 18-нд явагдах ба удирдамжийг нэгдүгээр шатны шалгаруулалтын дараа оролцох эрх авсан багуудад хүргүүлнэ.

Шагнал:

Нэгдүгээр шатны шалгаруулалт, хувийн дүнгээр:

- *Тэргүүн байр 1: Алтан медаль, өргөмжлөл, 80000 төгрөг*
- *Дэд байр 1: Мөнгөн медаль, өргөмжлөл, 70000 төгрөг*
- *Гутгаар байр 2: Хүрэл медаль, өргөмжлөл, 60000 төгрөг*
- *Тусгай шагнал 6: Өргөмжлөл, зөв хариулт бүрт нь 1000 төгрөгөөр бодож мөнгөн шагнал олгоно.*

Хоёрдугаар шатны шалгаруулалт, багийн дүнгээр:

- *1-р байр 1: Өргөмжлөл, шилжин явах цом, 350000 төгрөг*
- *2-р байр 1: Өргөмжлөл, 250000 төгрөг*
- *3-р байр 1: Өргөмжлөл, 200000 төгрөг*
- *Шагналт байр 2: Өргөмжлөл, тус бүр 150000 төгрөг*

Бүртгүүлэх журам:

Олимпиадад оролцох багууд **2013 оны 4-р сарын 22-наас 4-р сарын 26-нд 13.00-18.00 цагийн** хооронд МУИС-ЭЗС-ийн (хичээлийн IV байр) 403 тоотод ирж бүртгүүлнэ. Бүртгүүлэхэд дараах зүйлс шаардлагатай.

- Багийн 5 гишүүний оюутны үнэмлэх
- Эрхийн хураамж 20000 төгрөг

<http://econ.ses.edu.mn>

nyamaa47@gmail.com

Утас: 77307730(4129)

89004020

Монгол Улсын Их Сургууль

Эдийн Засгийн Сургууль

2013 он